

ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛЬД ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТНЫГ СУРГАН БЭЛТГЭЖ БУЙ БАЙДАЛ



Ш.ЛХАЧИНЖАВ

Дотоод хэргийн их сургуулийн захирал
доктор (Ph.D), профессор, хошууч генерал

Ази, Номхон далайн орнуудын хорих байгууллагуудын удирдах ажилтнуудын 39 дэх бага хуралд оролцогч эрхэмсэг хатагтай, ноёд та бүхний амрыг эрэн мэндчилье. Энэхүү бага хурлыг манай улсад анх удаа зохион байгуулж буйд бид талархаж байгаа бөгөөд бага хурал Монгол Улсын хорих байгууллагын алба хаагчдыг бэлтгэдэг үндсэн сургууль болох Дотоод хэргийн их сургуулийн түүхт 85 жилийн ойтой давхцаж байгаагаараа онцлог байна.

Дотоод хэргийн их сургууль нь Монгол Улсын хууль зүй, дотоод хэргийн салбарын мэргэшсэн албан хаагчдыг 1934 оноос хойш өнөөдрийг хүртэл бэлтгэж ирсэн, Монгол Улсын дээд боловсролын тогтолцоонд баттай байр суурийг эзэлсэн Монголын үндэсний ууган сургуулиудын нэг юм.

Хөгжлийнхөө түүхэн хугацаанд нийгмийг аюулаас хамгаалах, үндэсний аюулгүй байдлыг хангах, хууль зүй, дотоод хэргийн салбарын дээд боловсролтой эрх зүйч, команд-улс төрийн ажилтан мэргэжлүүдээр нийт 20 мянга гаруй, мөн 40 мянга орчим мэргэжлийн албан хаагчдыг бэлтгэж, эдгээр мянга мянган төгсөгчид маань эх орныхоо өнцөг булан бүрт тушаал өвөртлөн ажиллаж, нэр хүндтэй, хариуцлагатай үйлс болох гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, улсын хил хамгаалах, хорих байгууллагын аюулгүй байдал, шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, шинжлэн магадлах, гамшгаас урьдчилан сэргийлэх, авран хамгаалах ажиллагааг нэр төртэй гардан хэрэгжүүлэн ажиллаж байна.

Дотоод хэргийн их сургууль нь өнөөдөр эрдэм шинжилгээ-сургалт-үйлдвэрлэлийн шинж бүхий дээд боловсролын төрийн өмчит, нэгдмэл

төвлөрсөн удирдлагатай, төрийн чиг үүргийн бие даасан байгууллага бөгөөд Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэн, Хилийн албаны сургууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургууль, Цагдаагийн сургууль, Онцгой байдлын сургууль, Эрх зүй, нийгмийн ухааны сургууль, Ахлагчийн сургууль, Ахисан шатны боловсролын сургууль, Удирдлагын академи, Шинжлэн магадлахуйн институт, Ерөнхий боловсролын ахлах сургууль гэсэн бүрэлдэхүүн болон харьяа 10 сургууль, тусгай факультет, штаб, газар, хэлтэс, алба, багшийн хөгжлийн төв, эрүүл мэндийн төв болон бусад нэгжийн дэмжлэгтэйгээр мэргэжлийн боловсрол, бүрэн дунд, бакалавр, магистр, докторын шаталсан сургалтын хэлбэрээр 50 гаруй хөтөлбөрийг хэрэгжүүлж, судалгааны тэргүүлэх 30 орчим чиглэлээр эрдэм шинжилгээний үйл ажиллагаа явуулж байна.

Манай сургууль хууль зүй, дотоод хэргийн салбарын шинжлэх ухаан, боловсролын хөгжилд тэргүүлэх байр суурьтай, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, үндэсний болон бүс нутгийн аюулгүй байдлыг хангах үйл хэрэгт хувь нэмэр оруулагч, мэдлэг оюуны төв байхаар алсын хараагаа тодорхойлж, хууль зүй, дотоод хэргийн салбарын сургалт, эрдэм шинжилгээ, судалгаа, инновацийн хөгжлийн гол түшиц байгууллага болохоор зорин ажиллаж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийг бэлтгэж буй байдал

Анх 1974 онд Нийгмийг аюулаас хамгаалах яамны Цэргийн тусгай дунд сургууль, 1982 онд Цэргийн дээд сургууль, 1990 оноос Цагдаагийн дээд сургууль, 2000 оноос Цагдаагийн академи, 2011 онд Дотоод хэргийн их сургууль байгуулагдан ажилласан бүхий л хугацаанд хуучнаар Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллага, Хорих байгууллагуудын удирдах газар өнөөгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийг бэлтгэж ирсэн.

Тус Их сургуулийн харьяанд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчдыг бэлтгэх нэгжийг “Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн эрх зүй ба салбар эрх зүйн тэнхим (1986-1996)”, “Эрүүгийн ял эдлүүлэх эрх зүйн тэнхим (1996-2000)”, “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтныг бэлтгэх факультет (2000-2007)”, “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн тэнхим (2007-2011 он)” нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж ирсэн ба Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 229-р тогтоолоор байгуулагдсан Дотоод хэргийн их сургуулийн бүтцэд

“Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургууль” нэрээр их сургуулийн бүтцийн үндсэн нэгж буюу бүрэлдэхүүн сургуулийн статустай болж өргөжсөн.

Судалгаанаас үзэхэд 1974-2014 оныг хүртэл хугацаанд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын 1000 гаруй мэргэжилтэн төгссөн¹ ба сүүлийн 15 жилийн хугацаанд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын чиглэлээр бакалаврын сургалтын хөтөлбөрийг 521 мэргэжилтэн төгсжээ².

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь эрүү, иргэн, захиргаа, зөрчлийн хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх чиг үүрэг бүхий төрийн тусгай байгууллага бөгөөд энэхүү хуулиар хүлээсэн чиг үүргээ гүйцэтгэхэд мэргэшсэн төрийн албан хаагч чухал шаардлагатай. Дотоод хэргийн их сургуулиас дээрх шаардлагыг хангах өндөр “МЭДЛЭГ-УР ЧАДВАР-ХАНДЛАГА” бүхий мэргэжилтэн бэлтгэх зорилгоор сургалтын хөтөлбөрийн шинэчлэлтийг олон улсын болон нийгмийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн хэрэгжүүлж байна.

Тус Их сургуульд өнөөдрийн байдлаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчдыг дараахь шаталсан сургалтын тогтолцоогоор бэлтгэж сургаж байна.Үүнд:

1.Харуул хамгаалалтын амжилтныг бэлтгэх сургалт

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт зохион байгуулагдаж байсан 14 хоногийн томилогчдохын өмнөх сургалтыг 2013 оноос хойш тус Их сургуулийн харьяа Ахлагчийн сургуульд явуулдаг болсноор “Харуул хамгаалалтын албаны ажилтан” мэргэжлийн сургалтын хугацааг сунгах, сургалтын хөтөлбөрийг шинээр боловсруулахад анхааран ажиллаж сургалтыг 3 сар, үйлдвэрлэлийн дадлагыг 21 хоног болгон сургалтын хөтөлбөр, агуулгад өөрчлөлт оруулсны дүнд богино хугацааны сургалт буюу 2-3 сарын сургалтаар нийт 1402 суралцагчийг “Харуул хамгаалалтын албаны ажилтан” мэргэжлээр амжилттай сурган төгсгөжээ.

2.Бакалаврын сургалт

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургууль нь 2017-2018 оны хичээлийн жилд “Аюулгүй байдал-хууль сахиулах ажил”, “Нийгмийн ажил”, “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх-хууль сахиулах ажил” хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байсан бөгөөд 2019-2020 оны хичээлийн жилээс захиалагч байгууллагын алба хаагчид тавигдах шаардлагыг үндэслэн

¹ А.Лхагва.Тэнхимээс сургууль болж өргөжсөн түүхэн замнал.УБ.,2014 он. 7 дах тал

² Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хүний нөөцийн хэлтсийн тоон судалгаа 2019 он.

“Шүүхийн шийдвэр гүйцэтгэл-эрх зүй”, “Нийгмийн ажил” зэрэг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

2019 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар “Шүүхийн шийдвэр гүйцэтгэл-эрх зүй” хөтөлбөрөөр өдрийн ангид 260, эчнээ 3 жилийн ангид 69, 5 жилийн эчнээ ангид 56 суралцагч, “Нийгмийн ажил” хөтөлбөрөөр 20 сонсогч суралцаж байна.

Бакалаврын сургалтын хувьд суралцагчид 120 кредит цагийн хичээлийг судлан, тэнхимийн сургалтаас гадна захиалагч байгууллагын харьяа хорих ангиудад харуул хамгаалалт, нийгмийн ажил мэргэжлийн дадлагын ажлыг хийдэг.

Сонсогч, суралцагчидад сургалтын үйл ажиллагаанаас гадна бие даан болон багаар ажиллах ур чадварыг эзэмшүүлэх хүрээнд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор илтгэх, мэтгэлцэх урлагийн чадвар олгох “Бүргэдүүд”, албаны бэлэн байдал, бие бялдрын бэлтгэлжилт, бялдаржуулах урлагийн “Хар ирвэс” клубт суралцаж байна.

2019-2020 оны хичээлийн жилээс бакалаврын сургалтын суралцагчидыг 1-2 дугаар дамжаанд нь их сургуулийн дотуур байранд байрлуулан бие даан суралцахад дэмжлэг үзүүлэн, өнгөрсөн хичээлийн жилээс “MIU” олон улсын сургуулийн англи хэлний сургалтад хамруулж эхэлсэн нь гадаад хэлний өндөр мэдлэгтэй алба хаагчдыг бэлтгэхэд урагш алхсан алхам болсон.

2019 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр Дотоод хэргийн их сургууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар “Хамтран ажиллах санамж бичиг”-ийг шинэчлэн батлаж хүний нөөцийг бэлтгэх ажлын хүрээнд хэд хэдэн ажлыг хамтран зохион байгуулахаар тохиролцсон. Тухайлбал, ШШГЕГ-т ашигладаг програм хангамжийг сургалтын зорилгоор ашиглах, ШШГЕГ-ын харьяа 421 дүгээр нээлттэй, 409 дүгээр хаалттай, Цагдан хорих 461 дүгээр хаалттай хорих анги, Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх газар, Банк, хадгаламж зээлийн хоршоодоос төлбөр барагдуулах ажлын албыг сургалтын түшиц газар болгох, судалгааны ажлыг бодлогын түвшинд дэмжиж, практик алба хаагчдын оролцоог нэмэгдүүлэх, Дотоод хэргийн их сургуулийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн чиглэлээрх профессор, багш, алба хаагчдыг мэргэжлийн мэдлэг, ур чадвар, туршлага харгалзан томилон ажиллуулах хүрээнд олон асуудлыг хамтран шийдвэрлэсэн юм.

3. Магистрын сургалт

Дотоод хэргийн их сургуульд 2000-2018 оны хооронд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын 125 алба хаагч магистрын зэрэг хамгаалсан ба 2000-2005 онд жилд дунджаар 2 алба хаагч Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын чиглэлээр магистрын зэрэг хамгаалж байсан бол 2006-2012 онд 11, 2013 оноос тоон үзүүлэлт өсч жилд дунджаар 20-аас доошгүй алба хаагч магистрын зэрэг хамгаалах болжээ.

2019-2020 оны хичээлийн жилд тус их сургуульд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын 33 алба хаагч магистрын сургалтад хамрагдаж байна.

4. Докторын сургалт

Боловсрол, соёл шинжлэх ухааны сайдын 2014 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн а/168 дугаар тушаалаар тус Их сургуулийн дэргэд “Докторын ажил хамгаалуулах зөвлөл” байгуулагдсан ба Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын салбарын эрдэмтэд 2015 оноос хойш жил бүр 1 алба хаагч хорих ял эдлүүлэх ажиллагаанд хамаарах сэдвээр эрдмийн зэрэг хамгаалж байгаа нь тус салбарын судалгаа, шинжилгээний ажил ихээхэн эрчимтэй хөгжиж буйг харуулж байна. Тус их сургуульд өнөөдрийн байдлаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын 19 алба хаагч докторантурын сургалтад хамрагдаж байна.

5. Удирдах ажилтан бэлтгэх сургалт (шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн стратеги, тактик, удирдлагын өдөр, эцнээ 2 жилийн сургалт)

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын захиалгаар “Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн стратеги-тактик, удирдлага” мэргэжлийн сургалтын хөтөлбөрийн дагуу удирдахуйн ухааны албан тушаалын, стратегийн дамжаанд суралцагчдад тусгайлсан хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу богино хугацааны сургалтыг явуулж байна. “Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн стратеги-тактик, удирдлага” сургалтын хөтөлбөрөөр 2014-2018 оны хугацаанд нийт 13 албан хаагч төгссөн байх бөгөөд өнөөдрийн байдлаар ШШГЕГ-ын харьяа анги, нэгжид дарга, дэд дарга, ахлах мэргэжилтний түвшинд ажиллаж байна.

“Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн стратеги-тактик, удирдлага” мэргэжлийн сургалтын хөтөлбөрийн хүрээнд суралцагчдад өнөөгийн хүчин төгөлдөр хууль тогтоомжид нийцүүлэн эрүү, иргэн, захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны удирдлага, зохион байгуулалтын талаарх мэдлэг олгох сургалтыг зохион байгуулахаас гадна практик

байгууллагатай хамтран клиник сургалт, дадлага, “Команд-штабын сургалт”-ыг хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны бодит орчинд, тусгайлсан төлөвлөгөөний дагуу өгөгдөл өгч, болзошгүй бүхий л нөхцөлд ажиллах дадлага, чадвар эзэмшүүлэх зорилгоор зохион байгуулж байна.

Энэ хичээлийн жил Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын захиалгаар нийт 18 албан хаагч суралцаж байна.

Их сургуулийг хотхон хэлбэрээр хөгжүүлэх хүрээнд хичээлийн төв байрыг ашиглалтад оруулснаас гадна төв номын сан, биеийн тамирын цогцолборын шинэ байрыг 2020 онд ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байна.

Дотоод хэргийн их сургуулиас сургалтын үйл ажиллагаанд чанарыг эрхэмлэх, их сургуулийн үнэт зүйл болох профессор, багш нарын эрдэм шинжилгээ, судалгааны идэвхи, чадавхийг нэмэгдүүлэх, сургалтын хөтөлбөрийг боловсролын шинэ эрэлт хэрэгцээнд нийцүүлэх, сургалтын технологи, арга зүйг сайжруулах, онол практикийн хичээлийн зохистой харьцааг бий болгох, суралцагчийн хөгжлийг хангасан орчин нөхцөлийг бүрдүүлэх, үр дүнг бодитой үнэлэхийн тулд дотоод хяналт, чанарын баталгаажуулалтыг хөгжүүлэх, олон улсын болон дотоодын магадлан итгэмжлэл хийлгэх, чанарын хяналтыг системтэйгээр хэрэгжүүлэх асуудалд анхаарлаа хандуулан ажиллаж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын хөгжил

Эрүү, иргэн, захиргааны хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг гүйцэтгэх үндсэн чиг үүрэг бүхий Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын профессорын судалгааны баг нь Их сургуулийн эрдмийн зөвлөлийн 2013 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн “Профессорын баг байгуулах тухай” 6 дугаар тогтоолоор байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж байна.

Профессорын судалгааны багийн бүрэлдэхүүнд Дотоод хэргийн их сургуулийн шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын салбарын эрдэмтэн, судлаачид болон Монгол Улсын их сургууль, Шинжлэх ухаан технологийн их сургуулийн эрдэмтэн судлаачид багтаж байгаа бөгөөд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын удирдах алба хаагчид клиникийн профессор, зөвлөх профессороор ажиллаж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын профессорын судалгааны баг нь салбарын хэмжээний эрдэм шинжилгээний ажлын гүйцэтгэл, үр дүнг

хариуцан, магистр, докторын сургалтын суралцагчдыг судалгааны ажлыг удирдан чиглүүлж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын профессорын судалгааны баг нь ШШГЕГ-тай хамтран Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн салбарын тулгамдсан асуудлыг нээн илрүүлэх, шийдвэрлэх арга замын талаарх эрдэмтэн, судлаач, практик алба хаагчдын санал, зөвлөмжийг судалгааны эргэлтэд оруулах зорилго бүхий эрдэм шинжилгээний хурлыг 2012 оноос 2019 оныг хүртэл 10 удаа зохион байгуулснаас албан хаагчдын сургалт-3, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн орчин-4, хорих байгууллагад явуулах нийгэмшүүлэх ажил-2, хоригдлын үйлдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр-1 гэсэн сэдвийн хүрээнд явуулж иржээ.

Түүнчлэн суралцагчдыг салбарын хэмжээний эрдэм шинжилгээний ажилд татан оролцуулах зорилго бүхий “Шилдэг илтгэл, уран илтгэгч”, “Парлиаментын мэтгэлцээн”, “Оюуны индэр” тэмцээн, уралдааныг жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг.

2016-2019 оны хооронд Шинжлэх ухаан, технологийн сан, олон улсын байгууллагын санхүүжилтээр 320 гаруй сая төгрөгийн төсөл, хөтөлбөр /Хорих ял эдлүүлэх чиглэлээрх мэргэжлийн судлаачдыг чадавхжуулах нь, Дэлхийн зарим улс орнуудын хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны харьцуулсан судалгаа/-ийг хэрэгжүүлсэн нь тус салбарын судалгааны ажлын чанар, үр дүнг нэмэгдүүлэх, шинэ инновацийг бий болгоход чиглэсэн чухал ач холбогдолтой ажил болсон.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын захиалгаар болон практик алба хаагчдын хамтын ажиллагааны хүрээнд хамтарсан судалгаа-боловсруулалтын ажлыг хийн, үр дүнг практикт нэвтрүүлэх ажил улам эрчимжиж байна.

Монгол Улсын Дотоод хэргийн их сургууль нь Ази-Номхон далайн орнуудын хорих байгууллагуудтай хамтарсан судалгаа-шинжилгээний ажил гүйцэтгэх, харилцан туршлага судлах, тухайн орны хорих байгууллагын ажилтныг бэлтгэдэг сургуулиудтай “судлаач, багш, оюутан” солилцох зэргээр сургалт, судалгааны чиглэлээр бүх талын хамтын ажиллагааг өргөжүүлэх сонирхолтой байгааг энэ дашрамд илэрхийлэхийн зэрэгцээ хурлын үйл ажиллагаанд амжилт хүсье.